

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2018 оны 2 сарын дугаар.

Тэргүүн Мэдээ

Мал эмнэлгийн хүрээлэнгийн лабораторийн шинэ байрны нээлтийн ёслол.



Тууз хайчлах ёслол

2 дугаар сарын 3-ны өдөр Мал эмнэлгийн хүрээлэнгийн лабораторийн шинэ байрны нээлтийн ёслол боллоо. Шинэ лабораторид “Монгол оронд тохиолддог цусны шимэгч, эгэл биетнээр үүсдэг өвчний тархалтын судалгаа, оношлогооны оновчтой арга боловсруулах нь” SATREPS төслөөс туршилтын тоног төхөөрөмж, том оврын цахилгаан үүсгүүрийг суурилуулсанаар төслийн гол зорилт болох цусны шимэгч, эгэл биетнээр үүсдэг өвчнийг эрт илрүүлэх болон урьдчилан сэргийлэхэд чиглэсэн судалгаа шинжилгээний ажлын чадамжийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах юм. Монгол улсын аж ахуйн голлох салбарын нэг болох ХАА-н салбарт малын халдварт өвчний гаралт нэмэгдэх хандлагатай, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэхэд тулгарч буй асуудал болоод байна. Мал Эмнэлгийн хүрээлэн энэхүү төслөөс гадна Обихирогийн их сургууль, Хоккайдогийн их сургууль, Цукубагийн их сургуульд залуу судлаачдыг илгээж сургах зэргээр Япон улстай удаан хугацааны идэвхтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

Улс төр, эдийн засгийн чиг хандлага

УИХ ХХОАТ-ын шаталсан тогтолцоог халав.

2 сарын 2-ны өдөр 2018 оны 1 сарын 1-нээс нэвтрүүлсэн ХХОАТ-ын шаталсан тогтолцоог халах, тэтгэвэрт гарах насыг бууруулах тухай хуулийн төслийг УИХ хэлэлцэн батлав. ХХОАТ-ын шаталсан тогтолцоо нь Монгол улсын ЗГ-ын зүгээс авч хэрэгжүүлсэн санхүү, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ бөгөөд ОУВС-ын дэмжлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөлийн нэг болон тавигдсан боловч Засгийн газар өнгөрсөн жилээс эхэлсэн эдийн засгийн сэргэлтийг дагалдан татварын орлого нэмэгдэх хандлагатай байгааг харгалзан өндөр орлоготой иргэдийн татварын дарамтыг хөнгөвчлөх зорилгоор ийнхүү бодлого чиглэлдээ өөрчлөлт оруулсан байна. Эдийн засаг санхүүг сэргээн босгоход чиглэсэн цаашдын арга хэмжээ анхаарал татаж байна.

Төслийн хэрэгжилт

“Ерөнхий мэргэшил судлал сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй” сэдэвт сургалт болов.



Семинарт оролцогчид

1 сарын 30, 31-ний өдөр ТХА “Анхан ба хоёрдугаар шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн үйл ажиллагааны хүрээнд ЭМЯ, ЭМХТ, ЭМШУИС хамтран “Ерөнхий мэргэшил судлал сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулж, орон нутгийн нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд нийт 50 хүн оролцов. Японы Анагаах ухааны боловсролын холбооноос урилгаар ирсэн 4 мэргэжилтэн сургалтын хөтөлбөр боловсруулах дэлхий нийтийн чиг хандлагын талаар лекц уншихын зэрэгцээ сургалтын зорилго, арга барилын талаар гүнзгийрүүлэн хэлэлцсэн үр дүнтэй сургалт боллоо. Энэ удаа боловсруулсан хөтөлбөрийг үндэслэн стандартад нийцсэн ерөнхий мэргэшил судлал сургалтын хөтөлбөр боловсруулж дуусгах зорилго тавьж байна.

Хөрөнгийн зах зээлийн сурах бичиг гарлаа.



Хөрөнгийн зах зээлийн сурах бичиг

ТХА “Монгол Улсын Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд Япон улсын туршлагыг үндэслэн хувьцаа, засгийн газрын бонд ба санхүүгийн бүтээгдэхүүн, үнэт цаасны компаний бүтэц, холбогдох хууль тогтоомж, хөрөнгийн зах зээлийн тухай үндсэн ойлголт зэргийг багтаасан “Хөрөнгийн зах зээлийн сурах бичгийг” боловсруулан гаргалаа. Энэхүү сурах бичиг нь хөрөнгийн зах зээлтэй холбоотой хүмүүс төдийгүй иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд өргөн ашиглагдана гэж үзэж байгаа юм. Дээрх төслийн хүрээнд, хэрэгжүүлэгч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хорооны (FRC) хяналт, зохицуулалтын чадавхийг дээшлүүлэн, зах зээлд оролцогчдын ойлголтыг гүнзгийрүүлэх замаар хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэг, боловсролыг сайжруулах төсөл” 2018 оны Торгоны замын шагнал хүртэв.



Торгоны замын шагнал гардан авч буй Уэхара мэргэжилтэн (Голд нь)

ТХА “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэг, боловсролыг сайжруулах төсөл” МХАҮТ-ын 2018 оны Торгоны зам шагнал (Нийгмийн хөгжил, ядуурлыг бууруулах, тогтвортой амьжиргааг бий болгох чиглэлээр үр дүнтэй ажиллаж байгаа гэсэн **номинаци**) хүртэв. Энэхүү шагналыг 2 жилд нэг удаа Монгол орны эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулж буй гадаад, дотоодын байгууллага, хувь хүний санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөлд олгодог бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт оношлох, боловсролыг нь сайжруулахад чиглэсэн уг төслийн үйл ажиллагааг ийнхүү өндөрөөр үнэлсэн байна. Энэхүү төслийн хүрээнд цаашид монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн халамж, боловсролын орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын үйл ажиллагааны талаарх танилцуулга

Сайншандад “Бага ангийн боловсролын семинар” зохион байгуулав.



Семинарын явц

Боловсролын салбарт ажиллаж буй ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд өнгөрсөн жил Боловсролын дэд хороог үүсгэн байгуулсан бөгөөд тус дэд хорооны анхны семинар 2 сарын 7-ны өдөр Дорноговь аймгийн Сайншанд хотод зохион байуулагдав. Сайншанд хотын бага ангийн 40 гаруй багш оролцсон тус семинарт сайн дурын гишүүд “Хүүхэд төвтэй хичээлийн бүтэц” сэдвээр үзүүлэх хичээл явуулж, хичээлийн явцад хийж болох туршилтын аргуудыг танилцуулсан бөгөөд багш нар хичээнгүйлэн тэмдэглэх, асуулт асуух зэргээр идэвхитэй оролцож байлаа. Энэ удаагийн арга хэмжээ багш нарын арга барилыг баяжуулахын сацуу цаашдын үйл ажиллагаанд нь санаа авч хэрэгжүүлэхүйц агуулгатай байсан төдийгүй багш нарт тулгарч буй асуудлуудын талаар ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд ойлголт авах боломж олгосноороо ач холбогдолтой семинар болж өндөрлөлөө.

Сайн дурын бусад үйл ажиллагааны тухай мэдээ.

- Дэлхий даяарх ЖАЙКА-гийн сайн дурын үйл ажиллагааны тэмдэглэл:

Сайн дурын гишүүн Оно Юки (2016-2 ээлж /Нийгмийн ажилтан/ Дорнодын Их сургууль)→[Энд дарж үншина үү](#)



“Байгаль орчны боловсрол” семинар зохион байгуулагдлаа



Семинарт оролцогчид дурсгалын зураг авахуулав.

2 дугаар сарын 3-ны өдөр ЖАЙКА-ийн сургалт төгсөгчийн зохион байгуулсан “Байгаль орчны боловсрол” семинарт нийслэлийн 7 дүүрэг, Өвөрхангай, Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн биологийн 31 багш, “Шинэ Эрин” сургуулийн ахлах ангийн 19 сурагч оролцлоо. Семинар дээр “Шинэ Эрин” сургуулийн биологийн багш О.Онон “Байгаль орчны боловсрол” сургалтанд (ЖАЙКА Кюшү) хамрагдсан туршлагадаа тулгуурлан боловсруулсан “Биологийн дадлага ажил” гарын авлагаа ашиглан энгийн ажиглалт ба туршилт бүхий зарим дадлага ажлыг танилцууллаа. Семинарт оролцсон ахлах ангийн сурагчдын зүгээс ойлгоход хялбар, практик агуулгатай байлаа гэж үнэлэснээс үзэхэд хүрээлэн буй орчин болон экологийн асуудлын талаарх ойлголтыг гүнзгийрүүлсэн үр дүнтэй сургалт болсон нь харагдаж байна.



Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА) Монгол дахь төлөөлөгчийн газар.

**Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)
Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp**